



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхайрхан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/171/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улиастай сум

2024 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: bat-undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга
- 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
- 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
- 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
- 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
- 4.1 Ерөнхий зүйл.....
- 4.2 Материаллаг байдал.....
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
- 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Бусад асуудлын хэсэг

Баянхайрхан сумын Засаг дарга нь тайлант онд татварын орлогыг 280,262.6 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэл 275,929.6 мянган төгрөг буюу 1.6 хувиар тасарсан байна. Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт 51,783.6 мянган төгрөгийг 24 иргэнд буцаан олгосон байна.

Шилэн дансны цахим системд мэдээлбэл зохих 169 мэдээллээс 22 мэдээллийг хугацаа хоцроож, Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл хэсэгт татварын орлогыг, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ хэсэгт орлого, зарлагыг, мөн тухай бүр мэдээлэх 24 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		485,716.1	422,879.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	220,658.7	161,226.8
33	АВЛАГА	5а, 5б, 6а, 6б	251,486.6	188,706.1
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	0.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	13,570.9	72,946.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		587,000.2	826,960.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б, 12в	587,000.2	826,960.9
39200	Биет хөрөнгө		579,555.5	817,366.8
39300	Биет бус хөрөнгө	13	7,444.7	9,594.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II		1,072,716.3	1,249,840.2
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		1,072,716.3	1,249,840.2
51	Засгийн газрын хувь оролцоо		1,072,716.3	1,249,840.2
51100	Засгийн газрын оруулсан капитал		281,518.6	281,518.6
51200	Хуримтлагдсан үр дүн		618,993.2	796,117.1
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		172,204.5	172,204.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V		1,072,716.3	1,249,840.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)		1,359,992.0	1,509,960.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО		294,121.8	199,590.4
110	Орлогын албан татвар		96,412.2	141,896.3
1100	Хувь хүний орлогын албан татвар		122,474.0	193,679.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт		-26,061.8	-51,783.6
113	Хөрөнгийн албан татвар		28,375.7	37,196.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж		169,334.0	20,497.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	223,311.4	342,968.3
120	Нийтлэг татварын бус орлого		223,311.4	342,968.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		842,558.7	967,401.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	958,411.3	1,008,869.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ		958,411.3	1,008,869.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		431,802.4	960,268.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		223,958.4	399,346.3
2102	Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл		28,812.8	50,446.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		17,211.3	15,143.6
2104	Хангамж, бараа материалын зардал		28,505.6	32,585.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		4,713.7	5,404.3
2107	Томилолт, зочны зардал		6,970.6	9,706.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		15,283.1	14,440.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		106,347.0	433,195.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		526,608.8	48,601.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		401,580.7	501,091.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		3,780,206.9	323,967.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН		-3,378,626.2	177,123.9

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,457,226.0	4,457,226.0
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,072,716.3	1,072,716.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,451,342.5	4,451,342.5
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-5,883.5	-5,883.5
9	Тайлант үеийн үр дүн	-3,378,626.2	-3,378,626.2
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,072,716.3	1,072,716.3
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,249,840.2	1,249,840.2
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,072,716.3	1,072,716.3
19	Тайлант үеийн үр дүн	177,123.9	177,123.9

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	1,196,211.8	1,310,905.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	294,121.8	199,590.4
110	Орлогын албан татвар	96,412.2	141,896.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	122,474.0	193,679.9
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-26,061.8	-51,783.6
113	Хөрөнгийн албан татвар	28,375.7	37,196.8
118	Бусад татвар, төлбөр, хураамж	169,334.0	20,497.3
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	1,418.1	3,247.0
1181	Газрын төлбөр	773.0	2,324.3
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	166,630.0	14,926.0
1183	Бусад татвар	512.9	0.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	59,531.2	143,913.1
120	Нийтлэг татварын бус орлого	59,531.2	143,913.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	842,558.7	967,401.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	896,635.5	957,712.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	896,635.5	957,712.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	370,025.7	909,110.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	223,266.0	399,694.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	29,505.2	50,098.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,811.3	15,343.6
2104	Хангамж, бараа материалын зардал	23,836.9	31,885.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,844.7	8,314.9
2107	Томилолт, зочны зардал	6,970.6	9,706.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,193.1	16,900.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,598.0	377,167.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	526,609.8	48,601.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	299,576.2	353,193.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	203,718.1	367,525.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	203,718.1	367,525.0
2200	Дотоод эх үүсвэрээр	203,718.1	367,525.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-203,718.1	-367,525.0
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-43,286.3	-45,100.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЗЭЭЛ	43,286.3	45,100.0

VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	52,571.8	-59,431.9
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	168,086.8	220,658.7
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	220,658.7	161,226.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,409,970.2	1,233,443.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	926,084.0	862,718.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	926,084.0	862,718.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	419,565.9	399,694.2
210101	Үндсэн цалин	292,060.9	270,923.2
210102	Нэмэгдэл	118,821.3	95,843.8
210104	Урамшуулал	8,683.7	32,927.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,445.8	50,098.2
210201	Тэтгэврийн даатгал	35,663.1	34,216.5
210202	Тэтгэмжийн даатгал	4,195.6	4,025.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,356.6	3,172.0
210204	Ажилгүйдлийн даатгал	839.1	777.9
210205	Эрүүл мэндийн даатгал	8,391.4	7,906.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	251,861.7	239,373.2
210301	Гэрэл, цахилгаан	27,971.1	17,002.8
210302	Түлш, халаалт	221,789.0	221,717.0
210303	Цэвэр, бохир ус	2,101.6	653.4
2104	Хангамж, бараа материалын зардал	26,153.0	25,478.9
210401	Бичиг хэрэг	3,485.9	3,485.9
210402	Тээвэр, шатахуун	18,738.0	18,738.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,929.1	3,255.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,314.9	16,848.5
210604	Урсгал засвар	18,314.9	16,848.5
2107	Томилолт, зочны зардал	15,351.3	8,966.2
210702	Дотоод албан томилолт	15,351.3	8,966.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	18,038.0	16,900.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,700.0	15,700.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	710.0	150.0
210803	Даатгалын үйлчилгээ	469.1	469.1
210804	Тээврийн хэрэгслийн татвар	727.7	236.4
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	73.8	73.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	203.4	203.4
210807	Газрын төлбөр	138.3	68.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	15.7	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	124,353.4	105,358.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	118,550.0	99,560.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,803.4	5,798.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	393,886.2	325,625.0
223001	Бусад хөрөнгө	393,886.2	325,625.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЗЭЭЛ	90,000.0	45,100.0
230001	Эргэж төлөгдөх зээл	90,000.0	45,100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,409,970.2	1,298,169.6
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,108,387.9	1,179,012.1
320001	Орон нутгийн төсвөөс	839,094.0	909,718.2
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	269,293.9	269,293.9
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	301,582.3	119,157.5
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.0	119,157.5

350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	301,582.3	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	53,963.1
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	118,689.5

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Т3 цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	88,292.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	88,292.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	88,292.58
2104	Хангамж, бараа материалын зардал	6,406.81
210402	Тээвэр, шатахуун	6,386.81
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,000.00
210604	Урсгал засвар	19,000.00
2107	Томилолт, зочны зардал	740.00
210702	Дотоод албан томилолт	740.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,145.77
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	62,145.77
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	88,292.58
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	88,292.58
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	87,092.58

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхайрхан сумын Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги төлөвлөлт, хөтөлбөр, төслийг боловсруулах, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Эрхэм зорилго: Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Монгол улсын Засгийн газар, аймгийн Засаг дарга, сумын Засаг даргын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрүүд, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал түүний Тэргүүлэгчдийн хуралдаанаас гаргасан шийдвэрийг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд ажиллах төрийн байгууллага, мэргэжилтэн, албан хаагч багийн Засаг дарга нарын ажлыг уялдуулан оновчтой бодлого, зохицуулалтаар хангаж орон нутгийн хөгжлийн төлөө төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага иргэдэд төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэж, улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр иргэддээ үнэнч шударга үйлчлэхэд оршино.

Сумын хөгжлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 55 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж биелэлт 92 хувьтай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Баянхайрхан сумын Засаг дарга нь үйл ажиллагаандаа Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай, Шилэн дансны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай зэрэг хуулиудыг голлон мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхайрхан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нутгийн захиргааны байгууллагууд нь нийтлэг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхайрхан сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна. Тайлант оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 177,123.9 мянган төгрөгөөр буюу 16.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	220,658.7	161,226.8	(59,431.9)
Авлага	251,486.6	188,706.1	(62,780.5)
Бараа материал	13,570.9	72,946.4	59,375.5
Үндсэн хөрөнгө	587,000.2	826,860.9	239,860.7
Нийт хөрөнгө	1,072,716.3	1,249,840.2	177,123.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,072,716.3	1,249,840.2	177,123.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,072,716.3	1,249,840.2	177,123.9

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 161,226.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 59,431.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төгрөг			
Төрийн сангийн харилцах	220,658.7	161,226.8	(59,431.9)
Дүн	220,658.7	161,226.8	(59,431.9)

Эх сурвалж: Баянхайрхан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө өмнөх оны үлдэгдлээс 59,431.9 мянган төгрөгөөр буурсан нь 2022 оны давсан орлогоос сумын Орон нутгийн хөгжлийн сан болон Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд төсөв нэмж зарцуулсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Мөнгөн хөрөнгөтэй холбоотой зөрчил илрээгүй

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 188,706.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 62,780.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	-	-	-
Байгууллагаас авах авлага	36,138.2	13.4	(36,124.8)
Хувь хүмүүсээс авах авлага	215,348.4	188,692.7	(26,655.7)
Дүн	251,486.6	188,706.1	(62,780.5)

Эх сурвалж: Баянхайрхан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага өмнөх оны үлдэгдлээс 62,780.5 мянган төгрөгөөр буурсан нь байгууллагаас авах авлага 36,124.8 мянган төгрөгөөр, Хоршоо хөгжүүлэх сангийн хувь хүмүүсээс авах авлага 26,655.7 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Авлагатай холбоотой алдаа, зөрчил илрээгүй

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа данстай холбоотой үлдэгдэл тайланд тусгагдаагүй байна.

3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 72,946.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 59,375.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	1,919.5	1,919.5	0.0
Хангамжийн материал	11,651.4	61,326.9	49,675.50
Бичиг хэргийн материал	2,126.0	3,132.1	1,006.10
Аж ахуйн материал	542.1	707.1	165.00
Түлш, шатах тослох материал	3,605.4	13,096.8	9,491.40
Бусад хангамжийн материал	5,378.0	44,390.8	39,012.80
Мал амьтад		9,700.0	9,700.0
Дүн	13,570.9	72,946.4	59,375.5

Эх сурвалж: Баянхайрхан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материал дансны эцсийн үлдэгдэл 72,946.4 мянган төгрөгөөр өссөн нь ОНХС-ийн хөрөнгөөр 11,175.0 мянган төгрөгийн аж ахуйн материал бэлтгэж, данс бүртгэлд тусгасан, тайлант онд 112,721.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 64,520.8 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: Бараа материалтай холбоотой алдаа, зөрчил илрээгүй

3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгөтэй холбоотой бүртгэл байхгүй байна.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 826,960.9 мянган төгрөг болж, өмнөх оноос 239,960.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Газар	-	2,712.0	2,712.0
Биет хөрөнгө	579,555.5	817,366.7	237,811.2
Барилга, байгууламж, орон сууц	338,162.0	338,162.0	0.0
Авто-тээврийн хэрэгсэл	135,531.2	325,531.2	190,000.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	84,046.2	103,471.2	19,425.0

Тавилга, аж ахуйн эд хогшил	19,214.1	26,241.4	7,027.3
Зам гүүрний байгууламж	9,179.1	34,179.1	25,000.0
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3,660.0	3,660.0	0.0
Бусад үндсэн хөрөнгө	348,414.1	404,814.5	56,400.4
Ном	268.9		(268.9)
Биет бус хөрөнгө	7,444.7	6,882.3	(562.4)
Программ хангамж	4,277.0	4,277.0	0.0
Бусад биет бус хөрөнгө	5,908.0	5,908.0	0.0
Хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл	(364,660.5)	(421,995.5)	(57,335.0)
Дүн	587,000.2	826,960.9	239,960.7

Эх сурвалж: Баянхайрхан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 239,960.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 41,900.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдаж авсан, ОНХС-ийн хөрөнгөөр 69,825.0 мянган төгрөгийн, 191,800.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл үнэ төлбөргүй нэмэгдсэн, үлдэх өртөггүй хөрөнгийг үнэлж, 27,391.0 мянган төгрөгөөр хасагдаж, 31,323.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн, 12,873.9 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэрийн дагуу акталсан, тайлант оны элэгдлийн зардалд 97,331.0 мянган төгрөгийг тооцож, бүртгэсэн зэрэгтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт: ЗДТГ нь тайлант онд худалдаж авсан 19,000.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд зөв ангилж бүртгээгүй алдааг залруулсан байна.

3.5.7 Өр төлбөр

Өр төлбөр данстай холбоотой үлдэгдэл тайланд тусгагдаагүй байна.

3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,072,716.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 177,123.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	281,518.6	281,518.6	0.0
Өмч /төрийн/ /ТӨҮГ/	281,518.6	281,518.6	0.0
Хуримтлагдсан үр дүн	618,993.2	796,117.1	177,123.9
Өмнөх үеийн үр дүн	3,997,619.4	618,993.2	(3,378,626.2)
Тайлант үеийн үр дүн	(3,378,626.2)	177,123.9	3,555,750.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	172,204.5	172,204.5	0.0
Дүн	1,072,716.3	1,249,840.2	177,123.9

Эх сурвалж: Баянхайрхан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 177,123.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь шууд захирагчдын төсвийн төслийг нэгтгэдэггүй байна. Шууд захирагчид тус тусдаа төсвийн төслийг боловсруулан Төсвийн ерөнхийлөн захирагчийн холбогдох хэлтэст хүргүүлэн, нэгтгүүлж байна.

Сумын ИТХ-ын 2022 оны 15 дугаар тогтоолоор Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагыг 1,315,932.1 мянган төгрөгөөр баталжээ. Үүнээс орон нутгийн байгууллагын 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээ 1,018,467.5 мянган төгрөг байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэхээр 276,655.5 мянган төгрөгийг санхүүгийн дэмжлэгээс, 220,407.7 мянган төгрөгийг аймгийн ОНХС-аас сумд олгох орлогын шилжүүлгээс, Улсын төсөвт байгууллагуудын тогтмол зардал 297,464.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 237,172.0 мянган төгрөгийг татварын болон татварын бус орлогоос, 284.232.3 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс бүрдүүлэхээр сумын ИТХ-аар анх баталжээ.

Аймгийн 2023 оны төсвийн тодотголоор сумд олгох санхүүгийн дэмжлэгийг 87,995.2 мянган төгрөгөөр, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 48,886.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, баталсан байна.

Сумын ИТХ-ын 2023 оны 07 сарын 07-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор 2023 оны төсвийн жилд зарцуулах зарлагын нийт хэмжээг тодотгож, 1,409,970.2 мянган төгрөг болсон байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс санхүүгийн дэмжлэг 363,850.7 мянган төгрөгийн, аймгийн ОНХС-с сумдад олгох шилжүүлгээс 269,293.9 мянган төгрөгийн, улсын төсөвт байгууллагын тогтмол зардалд орон нутгийн төсвөөс 297,464.6 мянган төгрөгийн Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоор 72,557.7 мянган төгрөгийн, ОНХС-ийн орлогоос 46,599.8 мянган төгрөгийн, татварын болон татварын бус орлогоос 224,146.0 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 24,256.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн нь батлагдсан төсвөөс 111,800.6 мянган төгрөг дутуу байна. Энэ нь аймгаас олгох санхүүгийн дэмжлэг 800.0 мянган төгрөгөөр дутуу олгогдсон, ЗДТГ-т санхүүжилт дутуу олгосон, Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс орох орлогыг төлөвлөдөггүй, урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр тооцсон зэрэг нь нөлөөлж байна.

д/д	Санхүүгийн эх үүсвэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Санхүүгийн дэмжлэг	364,650.7	363,850.7	800.0
2	Аймгийн ОНХС-аас олгох шилжүүлэг	269,293.9	269,293.9	0.0
3	Улсын төсөвт байгууллагын тогтмол зардал	297,464.6	297,464.6	0.0
4	Татварын болон татварын бус орлого	250,519.3	224,146.0	26,373.3
5	Урьд оны үлдэгдэл	228,041.7	24,256.9	203,784.8
6	Үндсэн үйл ажиллагааны орлого		119,157.5	(119,157.5)
ДҮН		1,409,970.2	1,298,169.6	111,800.6

Татварын болон татварын бус орлогоор 275,929.6 мянган төгрөгийг бүрдүүлж, татварын буцаан олголтод 51,783.6 мянган төгрөгийг, санхүүжилтэд 224,146.0 мянган төгрөгийг олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,233,443.2 мянган төгрөг буюу 87.5 хувьтай байгаа нь сумын ЗДТГ-ын цалинг хэт өндөр төлөвлөсөн, дотоод албан томилолт, байгаль хамгаалах, орчныг нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг хэмнэсэн, ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан зарим ажил хийгдээгүй, Хоршоо хөгжүүлэх сангаас төлөвлөсөн хэмжээнд зээл олгоогүй, ЗДТГ-т санхүүжилт дутуу олгосон зэрэгтэй холбоотой байна.

Хүснэгт 8. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	114,370.8	112,631.7	1,739.1	98.5%
2	Засаг даргын Тамгын газар	565,748.6	517,523.2	48,225.4	91.5%
3	Орон нутгийн хөгжлийн сан	393,886.2	325,625.0	68,261.2	82.7%
4	Хоршоо хөгжүүлэх сан	90,000.0	45,100.0	44,900.0	50.1%
5	Улсын төсөвт байгууллагын тогтмол зардал	245,964.6	245,964.6	-	100%
ДҮН		1,409,970.2	1,233,443.2	176,527.0	87.5%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 88,292.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 20,167.4 мянган төгрөгийг тээвэр шатахуун, шуудан холбоо, урсгал засвар, дотоод албан томилолт, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд хэрэгжсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхайрхан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн төсвийн шууд захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхайрхан сумын Засаг дарга нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 1/36 дугаартай албан тоотоор ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,715,688.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 25,735.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 19,301.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, аудитыг гүйцэтгэх шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 20 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

Аудитын илрүүлэлт: Баянхайрхан сумын Засаг дарга нь Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 169 мэдээллээс 22 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож, 59 мэдээллийг огт мэдээлээгүй, Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл хэсэгт орон нутгийн татварын орлогыг мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар зөвлөмж өглөө.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжтой холбоотой алдаа, зөрчил илрээгүй байна.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Баянхайрхан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд завсрын аудит хийгдээгүй байна.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	-	-	-	-	-
Нийт дүн	-	-	-	-	-

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал тодорхойлогдоогүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт дотоод хяналт, хариуцлагатай холбоотой 24,986.5 мянган төгрөгийн болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илэрч, 2 заалт зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн 24,986.5 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс 748.8 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

5.2 Албан шаардлага өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: ТШЗ-ийн санхүүгийн аудитаар илэрсэн алдаа зөрчилд дүн шинжилгээ хийхэд ХХС-ийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 13,169.9 мянган төгрөгийг шүүхэд хандаагүй, ОНХС-ийн хөрөнгөөс 5,000.0 мянган төгрөгөөр малчдын чуулган зохион байгуулж, тэмцээний шагнал, хоолны зардал гаргасан, Засаг даргын нөөц хөрөнгөөс 6,816.5 мянган төгрөгийг бэлэг дурсгал, хоолны зардалд зарцуулсан нийт 24,986.5 мянган төгрөгийн зөрчил нь сумын Засаг даргын үйл ажиллагаатай шууд хамааралтай байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх”, 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.4-т “Сум дүүргийн Засаг даргын чиг үүрэг”, 3.4.3-т “Сум, дүүргийн хэмжээнд орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих”, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.3-д “энэ журмын 3.4.2-т заасан төслийг хэрэгжүүлэх хуулийн этгээд, иргэнтэй холбогдох хууль, журмын дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулж, биелэлтийг хангуулах, төслийн явц, үр дүнд байнгын хяналт тавих”, 3.4.11-д “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх, батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, арга зүйгээр хангаж, холбогдох хууль, журмыг хэрэгжүүлж ажиллах;

2. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 169 мэдээллээс 22 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож, 59 мэдээллийг огт мэдээлээгүй, Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл хэсэгт орон нутгийн татварын орлогыг мэдээлээгүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.1.5-д “улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний гүйцэтгэлийн сар, улирал, хагас болон бүтэн жилийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэ журмын 4 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар”, 3.2.10-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар” гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд, үнэн зөв байршуулж, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалтыг мөрдөж ажиллах, 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь хэсэгт 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй ажил гүйлгээг, Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл хэсэгт орон нутгийн татварын орлогыг мэдээлж хэвших;

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	АТТ	Тоо	Дүн
ХХС-ийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 13,169.9 мянган төгрөгийг шүүхэд хандаагүй, ОНХС-ийн хөрөнгөөс 5,000.0 мянган төгрөгөөр малчдын чуулган зохион байгуулж, тэмцээний шагнал, хоолны зардал гаргасан, Засаг даргын нөөц хөрөнгөөс 6,816.5 мянган төгрөгийг бэлэг дурсгал, хоолны зардал зарцуулсан нийт 24,986.5 мянган төгрөгийн зөрчил нь сумын Засаг даргын үйл ажиллагаатай шууд хамааралтай байна	1	24,986.5					1	24,986.5				
Дүн	1	24,986.5					1	24,986.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 169 мэдээллээс 22 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож, 59 мэдээллийг огт	1						1	

мэдээлээгүй, Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл хэсэгт орон нутгийн татварын орлогыг мэдээлээгүй байна.								
Дүн	1						1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1						1	

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.БАТ-УНДРАА

Х.БОЛДБААТАР

БОЛОВСРУУЛСАН:

АХЛАХ АУДИТОР

Ц.ОЮУНСУВД



Огноо: 2024-03-25